



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 1 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

“Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 03/03 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар байгуулсугай:

- |         |   |
|---------|---|
| Ахлагч  | -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд                                       |
| Гишүүд: | -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;                  |
|         | -Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;                        |
|         | -Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;                       |
|         | -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;                                 |
|         | -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;               |
|         | -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;           |
|         | -Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;               |
|         | -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; |
|         | -Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;                  |
|         | -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;             |
|         | -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  |
|         | -Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;                            |

- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Стандарт, хэмжил зүйн газрын дарга;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал.

Нарийн бичгийн дарга:

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ